МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт
Манлайлна

Барилгаидаараа Бахархья Жил

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

01-Р САР

2026

International Federation of Asian and Western Pacific Contractors' Associations (IFAWPCA)
"Board Member"

FIDIC International of consulting engineers
"Associate Member of FIDIC"

www.mnca.mn

МБҮА

+976-7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn

Монголын Барилгын
Үндэсний Ассоциаци

РЕДАКЦИ

ХЯНАН ТОХИОСОН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ЭНХБААТАР

НЭГТЭЛ РЕДАКТОР:
Б.ТӨВШИНБОЛОР

ОРОЛЦСОН:
АЖЛЫН АЛБА

АГУУЛГА

НИЙГМИЙН ҮНЭ ЦЭНИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО:

УДИРДЛАГЫН МАНЛЛАЙЛЫГ ХАНГАЖ, НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

САЛБАРЫН БОДЛОГО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

ГИШҮҮНЧЛЭЛ, МРКЕТИНГ, СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна



+ 976 7011 1515 www.mnca.mn

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

21 АЙМАГТ АССОЦИАЦИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ байгуулж эхэллээ

АССОЦИАЦИ НЬ САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДТЭЙ ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАНА.

- Сургалт, зөвлөгөөн
- Туршлага солилцоо
- Төслүүд, хөрөнгө оруулалт
- Шударга өрсөлдөөн, стандартын хяналт

7011 1515 info@mnca.mn

www.mnca.mn



БАЯН-ӨЛГИЙ **ХОВД** **ДАРХАН-УУЛ**

Аймгуудад САЛБАР ЗӨВЛӨЛ-ийг байгуулаад байна.

МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ

2026 Зохион байгуулагдах томоохон арга хэмжээнүүд

Зөв зүгт Манлайлна

Арга хэмжээний нэр	Огноо	Зорилго
“Construction market-2026”	2026.04-р сар	МУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, барилга бүтээн байгуулалтын салбарт хэрхэн нөлөөлөх, барилгын зах зээлийн нөхцөл байдал, санхүүжилт хөрөнгө оруулалт, судалгаа зэрэг нэгдсэн мэдээ, мэдээллийг хүргэх.
“Барилгын салбарын Удирдах ажилтнуудад зориулсан ХАБЭА сургалт” *(Төв, Хангайн болон Зүүн бүсийн аймгуудад)*	2026.03-11 саруудад	ХАБЭА-н хууль тогтоомж, эрсдэлийн удирдлага болон байгууллагын ХАБЭА -н зохион байгуулалтын мэдлэг, чадвар олгохоос гадна барилгын үйл ажиллагаа тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах заавар зөвлөгөөг хүргэх.
“Барилгачдаараа Бахархья-2026”	2026.01-12-р саруудад	Барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан байгууллагын болон Гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах компанит ажил.
“Барилгын салбарын ажиллах хүчний асуудал гарц, шийдэл”	2026.05-р сар	Барилга, дэд бүтцийн салбарын ААНБ-уудын ажил олгогчдод нэн шаардлагатай ажиллах хүчний хэрэгцээ, мэргэжлийн ур чадварын түвшин, хөдөлмөрийн нөхцөл, болон дотоодод дутагдаж буй хүний нөөцийг гадаадаас оруулж ирэх боломжийг бий болгох
Барилгын үйл ажиллаагаааны тусгай зөвшөөрлийн өөрчлөлт-шинэлэлт- үр дүн *Хэлэлцүүлэг, Нээлттэй өдөрлөг*	2026.11-р сар	• Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар олон талын саналыг сонсож, хэлэлцэж, шийдвэр, гаргалгаа, санал хүсэлтийг авах • Салбарт үзүүлэх Ассоциацийн байр суурийг илэрхийлэх, нөлөөлөх.
“Барилгачдын нэгдсэн чуулган-2026”	2026.12-р сар	Барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, нэр хүндийг өсгөх
“Construction Award-2026”	2026.12-р сар	Барилгын салбарын шилдэг ААНБ-уудыг шалгаруулах, тэдгээрийг алдаршуулах

Хэвлэмэл товхимолын нэр

“МУ-ын барилгын салбар - 100” тоон эмхэтгэл	2026.04-р сар	
“Өнөөдрийг бүтээсэн 100 жил” алдаршуулах товхимол	2026.09-р сар	Салбарт үзүүлэх Ассоциацийн байр суурийг илэрхийлэх, нөлөөлөх. Гишүүдийг сэтгэл ханамжийш дээшлүүлэх.

Арга хэмжээ, товхимлыг ивээн тэтгэн, хамтран ажилласнаар:

- **2026 онд Ассоциацаас зохион байгуулагдаж буй арга хэмжээ бүрт ЛОГО-г байршуулах** / баннер, постер, станд, видео шторк, байгууллагын албан ёсны сошиал холбоосыг сошиал хуудсанд байршуулах гэх мэт/
- **Арга хэмжээнд үйл ажиллагаагааг сурталчлах, танилцуулах**
- **Эмхтгэл, товхимолд өнгөт сурталчилгааг байршуулна.**
- **Бусад**

Дэлгэрэнгүй мэдээллийг:
+(976) 8803 5708
+(976) 9102 1020

2026 САЛБАРЫН БОДЛОГО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР



ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСӨЛД МБҮА ТББ ХАМТРАН ОРОЛЦОХООР САНАЛ СОЛИЛЦЛОО



Нийслэлийн орон сууцны корпорацийн Гүйцэтгэх захирал М.Говьсайхан, Орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү нартай МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан Улаанбаатар хотод хэрэгжиж буй гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүд, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах төслийн хүрээнд төр болоод төрийн бус байгууллагууд хэрхэн хамтран ажиллах боломжтой талаар 2026.01.21-ны өдөр санал солилцлоо.

Нийслэлийн орон сууцны корпораци нь гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүд, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах, дэд төвүүдийг орон сууцжуулах, түрээсийн орон сууцны олон талт хэлбэрийг хөгжүүлэх гээд олон чиг үүргийг хэрэгжүүлж байгаа билээ. Тус төслүүдийг хэрэгжүүлэхэд НОСК-ийн зүгээс дэд бүтэц, техникийн зөвшөөрлийг өгөх, архитектур төлөвлөлтийн зургийг батлах, оршин суугчидтай гэрээ хэлцэл хийхэд дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа ч иргэдийн үл зөвшилцлөөс шалтгаалж төсөл удаашрах, хугацаа алдах зэрэг бэрхшээлүүд тохиолдож байгааг дурдаж байлаа.

Харин МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь Ассоциацийн гишүүн байгууллагууд нь консорциум хэлбэрээр нэгдэж ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах төслийг хэрэгжүүлэхдээ нэг хоёр байшингаар нь хийж байгааг нэг гудамж, блокоор нь цогц байдлаар төсөл хэрэгжүүлэх нь үр ашигтай талаар саналаа илэрхийллээ. Нэг гудамж, блокоор нь төсөл хэрэгжүүлснээр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, архитектур, дизайн, төлөвлөлтийн хувьд хотын стандартад нийцнэ, Нөгөө талаар төслийн үр ашиг, гүйцэтгэлийн хувьд үр дүнтэй, ач холбогдолтой байх юм.

Мөн орон сууцны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ мэргэжлийн холбоотой хамтран хот төлөвлөлт, төр хувийн хэвшлийг оролцуулан төслийн загварчлалыг боловсруулах, оновчтой байдлаар шийдэх, харилцан үр ашигтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх нь чухал болохыг онцоллоо.

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД

Улсын Их Хурлын дарга Н.Учрал нь Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2025.12.17-ны өдөр өргөн барьсан бөгөөд зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, зах зээлд нэвтрэхэд аж ахуйн нэгжүүдэд тулгардаг саад хоригийг багасгах, хуульд нийцээгүй захиргааны хэм хэмжээний акт, журмаар холбогдох харилцааг зохицуулж, зөвшөөрөл олголтыг хүндрүүлж байгааг арилгах, цахим болгож, зөвшөөрөл авах нөхцөлийг шуурхай, хүндрэл чирэгдэлгүй болгохоор төсөл холбогдох зохицуулалтыг тусгасан байна.

Тус хуулийн үзэл баримтлалын талаар МБҮА ТББ-ын гишүүн байгууллагууд болох барилгын компанийнхан цувралаар байр сууриа илэрхийлж байна.

Талуудын байр суурь

МБҮА ТББ-ын Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар: ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ 1-3 ХОНОГТ БАГТААН ОЛГОДОГ БОЛГОСОН



МБҮА ТББ нь 2018 оноос барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг салбарын Түншлэгч /7/ төрийн бус байгууллагатай хамтран давхар хяналтын дор хэрэгжүүлж байгаа нь салбартаа төдийгүй бусад салбарт төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны САЙН ЖИШИГ болж байгаа билээ.


Тухайлбал Дэлхийн банк Монгол Улсын БҮАТЗ олгох үйл ажиллагааг төрийн бус байгууллагад шилжүүлснээр БИЗНЕСИЙН ОРЧИН сайжирч “DOING BUSINESS” индексийн үзүүлэлтээр дэлхийн 190 орноос 29-р байранд ЭРЭМБЭЛЭГДСЭН-ийг олон нийтэд зарлаж байсан билээ.

Бид БҮАТЗ олгох үйл ажиллагааг 2019 онд хагас цахимжуулсан бол 2021 оноос бүрэн цахимжуулж төрийн үйлчилгээний ХУР, ДАН, И-МОНГОЛ системүүдтэй холбож, барилгын салбарын нэгдсэн мэдээллийн санг бий болгон холбосон. Энэ систем нь хүний оролцоогүй, ил тод, нээлттэй, түргэн шуурхай үйлчилгээтэй, аливаа дундын зуучлалгүй, салбарын инженер, техникийн ажилтнуудын статистик тоон үзүүлэлтийг нэгтгэсэн, ХҮНД СУРТАЛ, АВЛИГААС АНГИЖРУУЛСАН СИСТЕМИЙГ Монгол Улсад нэвтрүүлснээрээ онцлог, давуу талтай болсон юм.

Гэсэн ч барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүсэлт гаргах, хянах, шийдвэрлэх үйл ажиллагаа нь цаасан материал бүрдүүлэлт ихтэй, ирүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах, тодруулах, лавлагаа авах гэх мэт хүний оролцоо ихтэй, цаг хугацаа шаардсан үйл ажиллагаатайгаас гадна мэдээллийн үнэн зөв, баталгаат байдал хангалтгүй, бусад мэдээллийн сангийн цахим системүүдтэй холбогдох боломжгүй байсан зэрэг хүндрэл, дутагдалтай асуудлуудыг цэгцлэх хүрээнд www.license.mn системд буюу E-mongolia-д 2025.09.05-ны өдрөөс шилжүүлснээр тусгай зөвшөөрөл авахад дунджаар 21 хоног зарцуулдаг байсан бол 3 хоногт багтаан тусгай зөвшөөрлийг авах боломжтой болоод байна.

Мөн 2026 оноос Зөвшөөрлөө аваад үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан хяналт тавих ажлыг эрчимжүүлэхээр ажиллахаар болоод байна.

МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч, NCD GROUP ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Хүрэлхүү: ШААРДЛАГАА ХАНГАСАН Л БОЛ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛДАГ БАЙМААР БАЙНА



Бизнес эрхлэгчийн хувьд төрөөс гаргаж байгаа Зөвшөөрөлтэй холбоотой шийдвэрийг алгаа ташаад хүлээж авч байна. Монгол Улс байгаль цаг уурын хувьд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх хугацаа тун бага байдаг бөгөөд олдож байгаа хугацаандаа төрийн элдэв бичиг цаасны ажил гэхээсээ бүтээн байгуулалтын ажилдаа төвлөрөх, цаг заваа зарцуулах шаардлагатай байдаг.

Тиймээс бодит амьдрал дээр зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа доголдолгүй тохиолдолд үйл ажиллагааг явцын хяналтаар шууд сунгадаг байх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг цэгцлэх, багасгах, эрх зүйн зохицуулалтыг ойлгомжтой болгох шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл юуг нь зөвшөөрлөөр олгох юм, юуг нь мэдэгдлээр эрхлэх юм гэдэг үйл ажиллагааны жагсаалтыг тодорхой болгож, холбогдох журам, хяналт тавих зохицуулалтыг сайжруулж, зөвшөөрөл, мэдэгдэл хүлээн авах төрийн байгууллагын бүрэн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг маш тодорхой болговол аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа явуулахад амар хялбар болохоор байна.

МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, Монкон групп ХХК-ийн Ч.Дарханбаатар: ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ МАНАЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД ТҮЛХЭЦ БОЛНО

Манай компани Монгол орныхоо хөгжил, дэвшилд өөрсдийн хувь нэмрийг оруулж гар бие оролцон салбарын хөгжлийг дэлхийн түвшинд хүргэх зорилго тавин үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш багагүй хугацаа өнгөрчээ.

Бид хэрэглэгчид, захиалагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан өнгө үзэмж, чанар технологийн шаардлагад бүрэн нийцсэн дээд зэргийн тав тух сайтай барилгын иж бүрэн ажлыг гүйцэтгэхийг зорьж ажиллахын зэрэгцээ барилга угсралтын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн



шаардлагыг бүрэн хангаж ажиллахад ихээхэн анхаарал хандуулдаг ба энэ чиглэлээр салбартаа сүүлийн 3 жил тэргүүлэгч болон ажиллаж байна.

Миний болоод манай салбарынхны хувьд УИХ-ын дарга Н.Учралын өргөн бариад байгаа Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг зүй ёсоор талархан хүлээн авч байна. Хуулийн өөрчлөлтөөр Зөвлөх үйлчилгээг энгийн зөвшөөрлийн төрөлд оруулж бүрэн цахимжуулах гэж байгаа нь зөв зүйтэй бөгөөд энгийн зөвшөөрлийг 5 жилээр, тусгай зөвшөөрлийг 10 жилээр олгохоор заагдсан нь аж ахуйн нэгжүүдэд эрэг, таатай боломжийг олгож байна гэж харж байгаа. Энэ нь бизнес эрхлэгч бидэнд таатай орчин бүрдэж, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг багасгаж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, өрсөлдөөнт, чөлөөт зах зээлийн эдийн засгийг бүрдүүлж, аж ахуй эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах суурь зарчим, зохицуулалтыг бий болгох юм байна гэж ойлгосон.

МБҮА ТББ-ЫН УЗ-ИЙН ГИШҮҮН, БАРМОН ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ш.ҮНЭНБАТ: МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАД ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ

Төрийн үйл ажиллагаанд шинэ менежментийн аргыг нэвтрүүлэх буюу төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, зардлыг багасгах, үйлчилгээ үзүүлэх болон худалдан авах чиг үүргийг салгах, төрийн үйлчилгээг хувийн хэвшлээр гэрээгээр гүйцэтгүүлэх болон хувьчлах аргыг хэрэгжүүлснээр үр дүн нь нийгэмд буюу ААНБ-уудад л сайнаар нөлөөлнө. Тухайлбал ТББ-ууд нь иргэний нийгмийн нэг чухал төлөөлөл болж байдаг бөгөөд төртэй түншлэл тогтоох бус харин нийгэмд төрийн үйл ажиллагаанд хяналт тогтоох үүрэгтэйн хувьд тусгай зөвшөөрлийн ард яригддаг хүнд суртал, авлигын асуудал бүрэн арилна гэдэгт итгэлтэй байна.



Сая ч УИХ-ын дарга Н.Учрал зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, зах зээлд нэвтрэхэд аж ахуйн нэгжүүдэд тулгардаг саад хоригийг багасгах хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь цагаа олсон зөв шийдвэр бөгөөд төр юм бүхнийг өөрөө биш Мэргэжлийн холбоодод өгч хяналтаа тавих нь хамгийн зөв шийдвэр гэдгийг манай МБҮА ТББ тодхоноо харуулж байгаа.

БАРИЛГЫН КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЦАР ХҮРЭЭНИЙ ЭРЭМБЭ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН ХИЙХЭЭР УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



Монгол Улсад барилгын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ой энэ онд тохиож буйтай холбогдуулан 2026 оны 12 дугаар сард МБҮА ТББ нь “Констракшн авардс” арга хэмжээг зохион байгуулж салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа, цар хүрээний эрэмбийг тодорхойлохоор мэргэжлийн байгууллагатай хамтран судалгаа хийхээр болж байгаа ба тус ажлын хүрээнд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар, судалгааны менежер Б.Саранчимэг Эс Ай Си Эй ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Эрдэнэбилэг нар санал бодлоо солилцлоо. Тус ажлын хүрээнд барилгын компаниудын чадавхыг жилийн борлуулалтын орлого, төлсөн татварын хэмжээ, нийгмийн даатгал даатгуулагчийн тоо, гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, тухайн жил гүйцэтгэсэн байгаль орчинд ээлтэй барилгын дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн төсөл, тухайн жилд оруулсан өөрийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тухайн жилд шалгарсан тендерийн дүн, гарсан ослын тоо, гамшиг, ослын үед үзүүлсэн тусламж дэмжлэг, нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан хандив, тусламжийн байдал, оюутнуудад олгосон тэтгэлэг гэх мэт шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг тооцох нь үнэн зөв, бодитой болно гэдэг дээр нэгдсэн ойлголтод хүрлээ.

Цаашлаад дээрх судалгааны үр дүн нь Монгол Улсад төдийгүй дэлхийн улс орнуудын барилгын салбарынханд танигдах, судлагдах, хамтарсан төсөл хөтөлбөрүүдэд оролцох, тендерт оролцоход нь нэмэр томоохон бааз суурь болох юм.

МБУА

ГИШҮҮНЧЛЭЛ, МАРКЕТИНГ

Судалгааны чиглэлээр



ГИШҮҮДЭЭ СОНСЪЁ

2026.01-р сар

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилт, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан ажлын хүрээнд 2026.01-р сарыг “Гишүүдээ сонсъё” уриан доор дараах ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. Үүнд:

- Гишүүнчлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулан хүргэхээр мэдээлэл постер бэлтгэн холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд 2026.01-р сард нь барилгын материал үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Кирти тауэр консорциум ХХК гишүүнээр элслээ.
- Гишүүн байгууллагуудын захирлуудтай уулзаж санаа бодлын сонсох, уулзалтаас гарсан санал, зөвлөмжийг төлөвлөгөөт ажилдаа тусган ажиллах зорилгоор УУЛЗАЛТЫН ХУВИАР гарган дараах гишүүн байгууллагуудтай уулзан ажиллахыг зэрэгцээ мөн, дараах асуулга, судалгаа, хуудсыг шинэчлэн авах зорилгоор уулзав. Үүнд:
  -Гишүүнчлэлийн бүртгэлийн хуудас
  -Сэтгэл ханамжийн судалгаа-2025
  -Төрийн дээд одон медаль, цол тэмдгээр шагналаар тодорхойлох хүсэлтийн судалгаа зэрэг багтсан болно.

Гишүүн байгууллагууд:

- Ультрасоник ХХК
- БҮТИ ХХК,
- Батс-Өргөө ХХК,
- Заг Групп ХХК,
- Номин Констракшн Девелопмент групп ХХК,
- Макс Өргөө ХХК,
- Эфэс констракшн ХХК зэрэг болно.







Гишүүнчлэлийн гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, идэвхи оролцоог дэмжихэд чиглэгдсэн зорилгын хүрээнд гишүүн болох BIPV Mongolia ХХК-тай болон бусад төрийн болон ТББ-уудтай хамтран 2026.01.27-ны өдөр Барилгын хөгжлийн төвийн сургалтын танхимд зохион байгууллаа. Тус сургалтад нийт 130 гаруй оролцогчид оролцсон ба сургалтын үеэр Гүйцэтгэх захирал, төслийн удирдагч М.Энхбаатар “Дулаан шийдэл II” төслийн хэрэгжилт, үр өгөөжийн талаарх мэдээлэл өгөхийн зэрэгцээ сургалтын арга хэмжээ болон маркетинг контентын ажлыг гүйцэтгэн ажиллав.



“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ НОГООН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГ ХАНДЛАГА” ОЛОН ТАЛТ ОРОЛЦОО БҮХИЙ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Эрчим хүчний хэмнэлттэй ногоон төлөвлөлтийн чиг хандлага” сургалтыг ХББОСЯам, БХТ ТӨҮГ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо ТББ, Монголын Ногоон Барилгын хүрээлэн ТББ нар хамтран 2026.01.27-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтыг ХББОСЯ-ны Хэлтсийн дарга Д.Батзориг барилгын салбарын ногоон эдийн засгийн шилжилт, төр засгийн бодлогын талаар нээж үг хэлсэн бөгөөд УИХ-ын гишүүн Г.Лувсанжамцын зөвлөх Н.Нарантуяа Ногоон санхүүжилтын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 57-р тогтоолын талаар, МНБХ ТББ-ын УЗГ Б.Батжав “Шанхай хотын Ногоон барилгын инженерийн зураг төслийн баримт бичгийн Гүнзгийрүүлэлтийн журам”, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал, төслийн удирдагч М.Энхбаатар “Дулаан шийдэл II” төслийн хэрэгжилт, үр өгөөж, BIPV Mongolia ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Болорбайгаль “Эрчим



хүчний хэмнэлттэй ногоон орон сууцны эдийн засгийн үр өгөөж”, Орон сууцны В стандарт авсан туршлагаасаа “Амгалан резидэнс” хотхоны Үйл ажиллагаа эрхэлсэн захирал н.Эрдэнэпүрэв нар салбарын инженер техникийн ажилтнууд, захирлуудад танилцуулга хийлээ.

Мөн сургалт, арга хэмжээнд хүрэлцэн ирсэн инженерүүдэд Монголын Барилгын Инженерүүдийн Холбооноос барилгын салбарын мэргэжил дээшлүүлэх сонгон суралцах нэг багц цагийн гэрчилгээг гардууллаа.

СЭЛБЭ 20 МИНУТЫН ХОТ-ЫН ОЛОН НИЙТИЙН БҮСЭД ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ХУВИЙН ХЭВШЛИЙНХЭНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАЛАА



Сэлбэ 20 минутын хот-ын олон нийтийн бүсэд төсөл хэрэгжүүлэх сонирхолтой хувийн хэвшлийнхэнд нээлттэй сонгон шалгаруулалтыг 2026.01.16-03.02-ны 16:00 цаг хүртэл www.selbecity.mn вэб сайтаар хүлээж авахаар нээлттэй зарлаллаа. Сэлбэ хот нь нийт 158 га талбайд хэрэгжих бөгөөд 8575 айлын орон сууц, үйлчилгээ, соёл, бизнесийн цогц орчныг бүрдүүлэх хотын хөгжлийн томоохон бүтээн байгуулалт болох юм.

Сэлбэ хотын газрыг 2024 онд эрчимтэй чөлөөлж, нийт 113 блок барилгын ажлыг эхлүүлсэн. Эхний ээлжийн орон сууц 2027 оны тавдугаар сард ашиглалтад орно.

Төслөөс санал болгож байгаа эхний 15 бүсийн 12 бүс нь олон нийтийн, 3 бүс нь амины сууцаас бүрдэнэ. Олон нийтийн бүс 27.69 га талбай, амины сууцны бүс 15.17 га талбайг хамарна.

Нийслэлээс 2026 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласан ба барилгын салбарын бүтээн байгуулагчид, хөрөнгө оруулагчдаа дэмжихэд нээлттэй хамтарч ажиллахаа илэрхийллээ.

Тус төсөлд МБҮА ТББ-ын гишүүн байгууллага болох Монкон ХХК, Нутгийн буян групп ХХК нар гүйцэтгэгчээр ажиллаж байгаа бөгөөд тун удахгүй нийт Гишүүдийнхээ дунд уулзалт, арга хэмжээ зохион байгуулж тус төслийн олон нийтийн бүсэд хэрхэн хамтран ажиллах боломжийг хэлэлцэнэ.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МАРКЕТИНГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

Барилгын салбарын 100 жилийн ой 2026 онд тохиож буйтай холбогдуулан байгууллагын үйл ажиллагааг сурталчлан, танилуулах, брендийг бий болгох зорилгоор салбарын онцлог, үнэ цэнийг агуулсан орчин үеийн дизайн бүхий Ассоциацийн Барилгын

салбарын 100 жилийн ойд зориулсан ЛОГО-ны загвар дизайныг гарган, ашиглаж байна.

МБҮА ТББ-ын Ажлын албаны зүгээс 2026 онд тусгагдсан төлөвлөгөөт гишүүдэд болон олон нийтэд чиглэгдсэн ажлуудыг идэвхжүүлэх зорилгоор 10 төрлийн постер, 8 рийл, 22 мэдээ мэдээллийг бичиж нийтэлж байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан байна.









Гишүүн байгууллагадын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Олон Улсад зохион байгуулагдаж буй барилгын салбарын шинэ техник, технологитой танилцах бизнес-аялалыг жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаг бөгөөд энэ жилийн хувьд хамгийн эхний бизнес-аялалыг Мондаро ХХК-тай хамтран KOREA BUILD WEEK-2026 үзэсгэлэнгийн зар, постер мэдээллийг бэлтгэн, итвэхжүүлэлтийн ажлыг хийн ажиллаж байна. Энэ удаагийн бизнес-аялалд 25 ААНБ-ууд бүртгүүлээд байгаа бөгөөд бүртгэлийн болон зохион байгуулалтын ажил үргэлжилж байна.






БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЧИГЛЭЭР



- Зөвшөөрлийн нэгдсэн систем

Зураг 2. Хуулийн этгээдээс ирсэн хүсэлт шийдвэрлэлт, хуулийн этгээдийн тоогоор



Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох чиглэлээр 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Тайлант хугацаанд 162 хуулийн этгээдийн баталгаажуулалт хийлгэхээр ХББОССайдад хүргүүлээд байна. Эдгээрийн 704 ИТА-ны боловсролын мэдээлэл, давхцал шалгасан байна.
- 2026.01.20-ны өдрөөс хойш хуулийн этгээдээс ирсэн хүсэлтийг шийдвэрлэж ажиллалаа (Зураг 2).
- Холбогдох хууль, тогтоомжийн дагуу “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан давхардсан тоогоор 650 хуулийн этгээд болон иргэдэд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зөвөлгөө, мэдээллийг тухай бүр өглөө.


/www.license.mn/-д нийт 330 ААНБ-д улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна. 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 01 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл нийт **258 ААНБ,** түүний дотор барилга угсралтаар **216,** зураг төсөл **36,** өргөх байгууламж **6** ААНБ-ын баталгаажуулалт хийлээ.

- ХББОССайдын 2026.01.13-ны өдрийн 08 дугаар тушаалаар **166** хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг баталгаажуулж, мөн **162** хуулийн этгээдийн баталгаажуулалт хийлгэхээр ХББОССайдад хүргүүлээд байна. ХББОССайдын тушаалаар 2025.09.05-ны өдрөөс өмнө цаасан хэлбэрээр олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрчилгээг үндэслэн 24 хуулийн этгээдтэй гэрээ байгууллаа.
- ХББОССайдын 2025.12.17-ны өдрийн 265 дугаар тушаалаар **151,** ХББОССайдын 2026.01.13-ны өдрийн 08 дугаар тушаалаар **166,** нийт **317** аж ахуй нэгж байгууллагын нэрс баталгаажиж ирсэнтэй холбогдуулан нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал /Opendata.gov.mn/-д Барилга үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүчинтэй нийт 6949 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг ангилал тус бүрээр гарган байршуулсан (Зураг 3).

- Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хэлтсийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний 4 боть, ХББОССайдын 2025 оны тушаал 2 боть, зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн ХББОССайдын 2026.01.13-ны өдрийн тушаалаар баталгаажсан хүсэлт, материалын архивын нэгж 10 боть үүсгэлээ.
- АТГ, ХББОСЯ, Монголын Төмөр зам, ЗТЗХолбоо, БТХолбоо, МБИГХолбооноос ирсэн хүсэлтийн дагуу лавлагаа, мэдээллийг цаг тухайд нь гарган хүргүүлсэн.

илгээхэд тулгардаг асуудлаар тус бүр 10 минутын хоёр дэлгэрэнгүй видео зааварчилгааг бэлтгэн facebook фэйж, youtube.com, mcis.gov.mn-нд байршуулаад байна.
- 2026 оны 01 дүгээр сард “Гишүүдээ сонсъё” аяны хүрээнд МБҮА ТББ-ын 242 гишүүн байгууллагуудын барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл судалгааг гаргаж, гишүүнчлэл хариуцсан менежерт хүргүүлэн ажилласан.

Зураг 3. Нээлттэй мэдээлэл байршуулалт, хуулийн этгээдийн тоогоор



- БҮАТЗХ-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ХББОСЯ-д хүргүүлж, БҮАТЗХ-ийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган төсвийн хамт ХББОСЯаманд хүргүүлэхээр гүйцэтгэх захиралд хянуулж байна.
- Зөвшөөрлийн цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгүүлэх талаар “Санхүүгийн мэдээлэл технологийн төв”-д 2026.01.06-ны өдрийн 26/03 дугаар албан бичгээр хандаж систем хөгжүүлэлттэй холбоотой 10 санал хүргүүлсэн.
- License.mn цахим системийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, системд гарч буй алдааг засварлан ажиллахын зэрэгцээ license.mn болон mcis.gov.mn-д хүсэлт гаргах, бүртгүүлэх зэрэг хуулийн этгээдийн зүгээс хүсэлт



ДУЛААН ШИЙДЭЛ-2





"БАРИЛГЫН ДОТОР ДУЛААЛГЫН ТЕХНОЛОГИ" СЭДЭВТ ШИНЭ СУРГАЛТАД ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХҮҮДИЙГ ХАМРУУЛАВ





Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслөөс барилгын салбарын ААНБ, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах хүрээнд, 2026 оны 1 дүгээр сарын 22-нд “Барилгын дотор дулаалгын технологи” сэдэвт шинэ сургалт зохион байгууллаа. Сургалтыг төслийн хамтран хэрэгжүүлэгч ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв удирдан зохион байгуулсан бөгөөд төслийн 10 гаруй дулаалгын зөвлөх хамрагдсан.

Тус төвөөс өнгөрсөн хугацаанд барилгын гадна дулаалгын шийдлүүдийг боловсруулж, дулаалгын ажлыг гардан гүйцэтгэгчдэд технологийн арга аргачлал, зааварчилгаа өгөх сургалтуудыг тогтмол зохион байгуулж ирсэн. Барилгын гадна дулаалга нь хамгийн оновчтой бөгөөд дулаан алдагдлыг бууруулж, барилгын насжилтыг уртасгадаг онцлог, давуу талтай гэж үздэг. Нөгөө талаас дүнзэн байшинтай, гоёмсог чамин хийцлэл бүхий гадна фасадтай амины орон сууцтай иргэд, айл өрхүүд гол төлөв барилгын дотор дулаалга хийлгэх сонирхол, хэрэгцээтэй байдаг. Энэхүү эрэлт хэрэгцээнд тулгуурлан барилгыг дотор талаас дулаалах боломжит шийдлүүдийг тус төвийнхөн боловсруулж, энэ төрлийн дулаалгын технологиудын талаар төслийн дулаалгын зөвлөхүүдэд сургалт орсон нь энэ юм. Барилгын гадна болон дотор дулаалгын үед ханын хийцлэл, нөхцөл, орчинд нь тохирсон онцлог бүхий технологийн дарааллаар гүйцэтгэх бөгөөд аль ч тохиолдолд агаар сэлгэлтийг зайлшгүй шийдэж өгөх, дулаалгын ил, далд ажлын актыг үйлдэж байх шаардлагатай талаар сургалтад оролцогчдод зөвлөлөө. Ийнхүү Монгол Улсад хөгжил, хүмүүнлэгийн төсөл статустайгаар 8 дахь жилдээ хэрэгжиж буй, зах зээлд суурилсан "Дулаан шийдэл II" төсөл нь барилгын дотор дулаалгын шийдлүүд, өртөг тооцооллыг иргэд, олон нийтэд санал болгож эхлээд байна.

"ДУЛААН ШИЙДЭЛ II" ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ӨГӨӨЖИЙН ТАЛААР ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАНИЛЦУУЛЛАА



МБҮА ТББ нь ХББОСЯ, БХТ ТӨҮГ, Монголын барилгын инженерүүдийн холбоо

ТББ, Монголын ногоон барилгын хүрээлэн ТББ-тай хамтран 2026.01.27-нд “Эрчим хүчний хэмнэлттэй ногоон төлөвлөлтийн чиг хандлага” сэдэвт сургалтыг барилгын салбарын олон талын төлөөллийг хамруулан зохион байгуулсан. Сургалтын үеэр МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч М.Энхбаатар байгууллагынхаа хамтран хэрэгжүүлдэг “Дулаан шийдэл II” төслийн хэрэгжилт, үр өгөөжийн талаар оролцогчдод танилцуулав. Төслийн хүрээнд, барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын зах зээлийг хөгжүүлэх замаар одоогийн байдлаар 4800 гаруй айл өрхийг дулаалж, 200 гаруй барилгын салбарын бизнес эрхлэгчийг чадавхжуулан, Дархан-Уул аймагт хүрээгээ тэлж, барилгын салбарын хөгжил төдийгүй улс орныхоо хүн ам, байгаль, орчин, нийгэм, эдийн засагт бодит хувь нэмрээ оруулахаар зорин ажиллаж байгаа юм.

ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ДУНД САНАЛ, ХҮСЭЛТИЙН СУДАЛГАА ЯВУУЛАВ



МБҮА ТББ-ын "Дулаан шийдэл II" төслийн багаас жил бүр хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдийнхээ дунд “Санал, хүсэлтийн судалгаа” явуулж, дараа дараагийн жилүүдэд хамтран ажиллах чиглэлээ тохирч, тэдгээрийн эрэлт, хэрэгцээнд тохирсон төрөл бүрийн сургалт, арга хэмжээ, үйл ажиллагаа явуулахыг зорьдог.

2025 оны Санал, хүсэлтийн судалгаанд 40 гаруй дулаалгын зөвлөх, барилгын

BRIGADE SURVEY 2025

A total of 42 MSMEs participating in the “SOAP II” project took part in the Brigade survey 2025. Of these respondents, 28 were male and 14 were female.

In response to the question, *“Please rate the content and organization of the trainings organized by the project that you participated in (2–Poor, 3–Average, 4–Good, 5–Very good)”*, 29 respondents rated the trainings as Very good, while 13 rated them as Good. In other words, 69 percent of the participants expressed a high level of satisfaction with the content and organization of the trainings, while 31 percent were satisfied.

When asked, *“Please rate the content and organization of the events organized by the project that you participated in (2–Poor, 3–Average, 4–Good, 5–Very good)“*, 30 respondents rated them as Very good, 11 as Good, and 1 as Average. This indicates that the majority of respondents (71.2 percent) gave the highest rating, demonstrating that continued attention to the content and organization of project events remains important.

Regarding the question, *“Did the trainings you attended contribute to expanding your knowledge and information?”*, 41 respondents, or 98 percent, answered “Yes,” which is a very encouraging result.

In response to the question, *“Did the events you participated in contribute to the expansion of your business activities?”*, 36 respondents, or 86 percent, answered “Yes,” indicating that these events were effective. One respondent answered “No,” and six answered “Not sure.” These respondents were insulation consultants who did not participate in the relevant events.

To the question, *“Will you continue to cooperate with the ‘SOAP II’ project in 2026?”*, 40 respondents, or 95 percent, answered “Yes,” indicating a strong willingness to continue cooperation beyond the SOAP2 Y4Q4. The two respondents who answered “No” were Energy Advisors trained in Darkhan. One consultant reported that a loan approved based on their assessment had been returned, while the other expressed concerns about delays in the payment process for labor costs during the implementation of one insulation work financed through green loan funding.

The responses from each brigade can be viewed and reviewed via the link below.

https://drive.google.com/drive/folders/1_NhIPDnxaF1r1uKjrlaZAoW2vT0-uSZh?usp=drive_link

салбарын бизнес эрхлэгчид хамрагдан, тус онд төслөөс зохион байгуулсан сургалт, арга хэмжээнүүдэд сэтгэл ханамжтай байсан төдийгүй ирэх жилүүдэд дахин хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ. Тухайлбал, барилгын эрчим хүч хэмнэлт, дэвшилтэт техник технологи, төсөв санхүү зэрэг чиглэлийн чадавхжуулах сургалт, хөтөлбөрүүдэд үргэлжлүүлэн хамруулах, хамтын ажиллагааг дараагийн шатанд гаргах зэрэг тодорхой саналуудыг дэвшүүлсэн байв. Тиймээс бид хамтран ажиллаж буй барилгын салбарын бизнес эрхлэгчдээ чадавхжуулан хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах, цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь түлхэц болох/хувь нэмрээ оруулах зорилгоор тодорхой сургалт, арга хэмжээнүүд зохион байгуулахаар ажлын төлөвлөгөөндөө тусгасан болно.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАА УХАМСАРЛАСАН ЗАРИМ КОМПАНИТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖИЙГ ЭРЭЛХИЙЛЛЭЭ

2025.12.12-ны өдөр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар нар Жэрэс ОУТББ-ын Суурин төлөөлөгч Завьер Рат болон тус байгууллагын "Дулаан шийдэл II" төслийн Дэд менежер Ц.Сүнжидмаа нарыг хүлээн авч уулзан, "Дулаан шийдэл II"





төслийг үргэлжлүүлэн ур дүнтэй хэрэгжүүлэх болон цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Уулзалтын үеэр Суурин төлөөлөгч Завьер Рат нь төслийн үлдэгдэл хамтын санхүүжилтийг олохын тулд МБҮА ТББ нь төслийн II үе шатаа дуустал идэвхтэй ажиллахыг санал болгосон бол МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэгч, нийгмийн хариуцлагаа ухамсарласан зарим компани руу төслийн танилцуулгаа хамтран ажиллах тодорхой саналын хамт илгээж, хамтын ажиллагааны өргөн боломжийг эрэлхийлэхийг төслийн багийнханд зөвлөсөн юм.

Энэ дагуу МҮХАҮТ-аас зохион байгуулдаг “Entrepreneur 2025” шалгаруулалтын “Тогтвортой хөгжлийн зорилт хэрэгжүүлэгч энтрепренёр” шагналын зарим эзэд, мөн Монголын нийгмийн хариуцлагын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг томоохон групп компаниудад төслийн стандарт танилцуулга болон хамтран ажиллах тодорхой саналуудынхаа хамт хүргүүлж, хамтран ажиллах боломжийг эрэлхийлээд байгаа болно. Үүнд,

"Дулаан шийдэл II" төслийн хүрээнд МБҮА ТББ-тай хамтран ажиллах тодорхой саналууд:

- УБ хот болон Дархан-Уул аймгийн гэр хороололд аж төрж буй айл өрхүүдийг байшин, амины орон сууцных нь дулаан алдагдлыг илрүүлэх техникийн үнэлгээнд хамруулах
- УБ хот болон Дархан-Уул аймгийн гэр хороололд аж төрж буй айл өрхүүдийн байшин, амины орон сууцыг дулаалж, гэр бүлийн гишүүдийг дулаан, тав тухтай амьдрахад нь дэмжлэг үзүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулах
- Дулаан алдагдлыг илрүүлэх техникийн үнэлгээ, дулаалгын ажлыг технологийн дагуу хийж гүйцэтгэж буй УБ хот болон Дархан-Уул аймгийн, барилгын дулаалга, эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр сургагдсан барилгын салбарын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулан хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааг дэмжих

"Дулаан шийдэл II" төслийн стандарт танилцуулгатай танилцах холбоос:
https://drive.google.com/file/d/1U91WEw-ggdT-G9ciwwnGUOa5W6pgorrT/view?usp=drive_link

"Дулаан шийдэл II" төслийн танилцуулга болон хамтран ажиллах саналаа илгээсэн/хүргүүлсэн байгууллагууд:

- Юргана Индастри ХХК
- Монцемент Билдинг Материалс ХХК
- М-Си-Эс Групп
- Үнэт Санхүүгийн Нэгдэл

- Мобиком Групп / Мобиком Корпораци ХХК
- Түүлсмаркет ХХК

МҮХАҮТ-аас зохион байгуулдаг “Entrepreneur 2025” шалгаруулалтын “Тогтвортой хөгжлийн зорилт хэрэгжүүлэгч энтрепренёр” шагналт байгууллагуудын талаарх мэдээллийг дараах холбоосоор авах боломжтой.

https://www.facebook.com/share/p/1CFne1x3gg/

АМИНЫ ОРОН СУУЦЫГ ДУЛААЛАХ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ШИНЭ СУУЦ БАРИХ, УГСАРМАЛ ОРОН СУУЦЫГ ШИНЭЧЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ХЭЛЭЛЦЭХ УУЛЗАЛТАД ОРОЛЦЛОО



Төслийн хамтран хэрэгжүүлэгчдийн нэг Монголын Ногоон Санхүүгийн Корпораци (МНСК) нь Их Британийн Economic Consulting Associates (ECA) компанитай хамтран “Амины орон сууцыг дулаалах, эрчим хүчний хэмнэлттэй шинэ сууц барих, угсармал орон сууцыг шинэчлэхтэй холбоотой экстерналити (дам) зардал, үр ашгийн судалгаа”-г хийж гүйцэтгээд байна. Уг судалгааны үр дүн, ашигласан арга зүй, тооцоолол болон дүгнэлтийг хамтран хэлэлцэж, эцсийн тайланг баталгаажуулах уулзалт 2026.01.29-нд болж төслийн багаас МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар оролцлоо.

Судалгааг Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийн хүрээнд, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон Монголын ипотекийн корпораци (МИК)-ийн хамтарсан санхүүжилтээр явуулсан байна.

Судалгааны үндсэн дүгнэлтүүдээс дурдвал:

- Амины орон сууцыг дулаалах, эрчим хүчний хэмнэлттэй шинэ сууц барих, угсармал орон сууцыг шинэчлэх зэрэг арга хэмжээнүүд нь зөвхөн эрчим хүчний зардлын хэмнэлтээр тооцоход санхүүгийн өгөөж хязгаарлагдмал боловч эрүүл мэнд, байгаль орчин, уур амьсгалын экстерналити (дам) үр ашгийг тооцсон тохиолдолд эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой байна.
- Гэр хороололд нүүрс түлэх нь агаарын бохирдлоор дамжин нийгэмд асар их экстерналити зардал үүсгэж байгаа бөгөөд үүнийг барилгын дулаалга, цэвэр халаалтын шийдлүүдээр бууруулах боломжтой.
- Эрчим хүчний үнэ тарифыг одоогийн татаастай үнээр бус зах зээлийн бодит үнээр үнэлэх нь ногоон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын урт хугацааны экстерналити үр ашгийг илүү бодитой харуулж байна.

ДАРХАН-УУЛ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН МАРКЕТИНГИЙН КАМПАНИТ АЖЛЫНХАА ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАВ



Нийт хүрсэн үр дүн: Тоон үзүүлэлт

№	Сурталчилгааны суваг	Тайлбар	Тооцоолсон хүрэлт
1	Орон нутгийн ТВ - DBS	55 сек видеог 9 хоногийн турш өдөрт 2 удаа цацсан	~270,000
2	RGB ТВ	55 сек видеог 9 хоногийн турш өдөрт 2 удаа цацсан	~21,600
3	Dulaan Shiidel Facebook	Кампанит ажлын видео болон Өдөрлөгийн event пост boost	64,950
4	Инфлюенсер (Хөдөөний айл)	Пост, story, Өдөрлөгт биечлэн оролцсон	113,000
5	Онлайн медиа (RGB TV, Studio 21)	Видеог дахин нийтэлж, мэдээг түгээсэн	~3,275
6	Зурагт самбар	4×8 м баннер, 14 хоног байршуулсан	73,500
7	Өдөрлөг арга хэмжээ	Биечлэн оролцсон	550 (60% эмэгтэй)
	Нийт хүрсэн хүний тоо	(Давхардсан тоогоор, давтамжит үзэлт)	**546,875+**

Төслийг удирдан хэрэгжүүлэгч Жэрэс ОУТББ-аас ээлжит маркетингийн нэгжийн уулзалтаа 2026.01.13-нд зохион байгуулсан. Тус байгууллагаас Дархан-Уул аймагт зохион байгуулсан маркетингийн кампанит ажлынхаа үр дүнг төслийн хамтран хэрэгжүүлэгчдэдээ танилцуулсан уг уулзалтад манай төслийн баг оролцож, мэдээлэл авав. Кампанит ажлын хүрээнд, барилгын дулаалга, эрчим хүч хэмнэлтийн ач холбогдлын талаар богино хэмжээний видео танилцуулга бэлтгэн, аймгийн ТВ болон бусад мэдээллийн сувгаар хүргэн, тодорхой байршлуудад зурагт самбар байршуулж, иргэд, олон нийтэд зориулсан “Нээлттэй өдөрлөг” зэрэг арга хэмжээг зохион байгуулсан байна. Эдгээрээс манай төслийн баг “Нээлттэй өдөрлөг”-т оролцож, МБҮА ТББ-ынхаа болон төслийнхөө үйл ажиллагааг Дархан-Уул аймгийн 100 гаруй иргэдэд танилцуулсан юм.

2026.01-Р САРЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/д	Үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт
1.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	33
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	11
3.	Барилгын салбарын БЖДБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	19
4.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	2
5.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	32
6.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	11
7.	Санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн айл өрхийн тоо	35



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn